

ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН 2020 ОНЫ ТАЙЛАН МЭДЭЭ

Орхон аймгийн эрүүл мэндийн газарт 2020 онд иргэд, аж ахуйн нэгжээс нийт 212 өргөдөл гомдол, санал хүсэлт ирснээс бичгээр 55, цахимаар 146, биечлэн уулзаж 11 өргөдөл гомдол санал хүсэлт ирснийг хүлээн авч зохих хариу өгч ажиллаа.

2020 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 78 буюу 30,3 хувь нь Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалт, тусламж үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлт, 66 буюу 25,6 хувь нь салбарын холбогдолтой асуудлаар ямар нэг дэмжлэг, тусламж хүссэн, 27 буюу 10,5 хувь нь салбарын шагналтай холбоотой асуудал, 11 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 28 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 10,8 хувийг эзэлж байна.

2020 оны өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100 хувьтай байна.

Эрүүл мэндийн харьяа байгууллагуудад иргэдийн санал хүсэлтийг хурдан шуурхай шийдвэрлэх үүднээс АЗДТГ-ын дэргэдэх 70353511-д ирсэн санал хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж биелэлтийг Даваа гариг бүр АЗДШуурхай хуралд биелэлтийг танилцуулдаг бөгөөд ЭМСБ-уудын шуурхай болон албан хаагчдын шуурхай хуралд ДТБХА-н мэдээллийг тогтмол хийдэг уламжлалтай болно.

Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн хамтарсан Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх ажлын хүрээнд ЭМГ-ын өргөдөл гомдлын шийдвэрлэлттэй танилцаж зохих үнэлгээ өглөө.

2020 онд ЭМГ-ын ажилтнуудаас ЭМГ-ын удирдлагад гаргасан 65 өргөдлийг хууль журмын дагуу шийдвэрлэсэн болно.

2020 ОНД ИРГЭДЭЭС ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ
ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

| Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт хувь |
|---------------------|--------------------------------|------------------------|-------------------------------|-------------------------------|------------------|------------------|
| | | Шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| Эрүүл мэндийн газар | 212 | 212 | - | - | - | 100 |

2020 ОНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ

| Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт | Үүнээс | | | | |
|---------------------|--|---------|-----------------|----------------|-----------------|-------|
| | | Бичгээр | Цахим хэлбэрээр | Утсаар хандсан | Биечлэн уулзсан | Бусад |
| Эрүүл мэндийн газар | 212 | 55 | 146 | - | 11 | - |

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

| Байгууллагын нэр | Зонхилж байгаа асуудал тоо, /нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/ |
|---------------------|---|
| Эрүүл мэндийн газар | 2020 онд ирсэн нийт өргөдлийг агуулгаар авч үзвэл 68 буюу 30,3 хувь нь салбарын ажилтай холбоотой санал, хүсэлт, , 58 буюу 10,5 хувь нь салбарын албан хаагчдад талархасан асуудал, 65 буюу 4,2 хувь нь ажилд орохыг хүссэн өргөдөл байна. Мөн энэ онд 21 гомдол ирсэн бөгөөд нийт өргөдлийн 21 хувийг эзэлж байна. |

.....оОо.....